



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/376

Мөрөн сум

Газар эзэмших эрхийг дуусгавар  
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, заалт тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2009 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн №404 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 1 дэх заалтаар газар эзэмшигч “Хөвсгөл аймгийн тавдугаар цэцэрлэг” /4140265/-ийн Мөрөн сум 2 дугаар багт байршилтай 4286м<sup>2</sup> сургалтын зориулалттай эзэмшил газрынхаа газар эзэмших гэрчилгээ, гэрээгээ цуцлах хүсэлт гаргасны дагуу газар эзэмших эрхийг нь дуусгавар болгож нийтийн эзэмшилд шилжүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байсан “Хөвсгөл аймгийн тавдугаар цэцэрлэг” /4140265/-ийн 0380592 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож газар эзэмшигчийн мэдээллийн сангаас хасалт хийхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН